

БАТЛАВ.

АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА
/Д.ЧАНДМАНЬ/ *[Signature]*



БАТЛАВ.

САУСГОБИ СЭНДС
ЕРӨНХИЙЛӨГЧ БӨГӨӨД ХХК-ИЙН
ЗАХИРАЛ /Ч.МӨНХБАТ / *[Signature]*

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2017 оны 03 сарын 7-ны өдөр

Дугаа 17/01.

Даланзадгад сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу "Монгол-Ус" Төрийн Өмчтэй Үйлдвэрийн Газрын гаргасан 2017 оны 01-р сарын 25-ны өдрийн 20 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Алтайн Өвөр Говийн сав газрын захиргааны олгосон 2017 оны 03 сарын 07-ны өдрийн А-2 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг тус тус үндэслэн:

Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж Алтайн Өвөр Говийн Сав газрын захиргааны Усны нөөц, ашиглалтыг зохицуулах албаны мэргэжилтэн Бадралтхүү овогтой Алтантулга.

Нөгөө талаас: Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 15-р хорооны Оргил стадион 22, Моннис Бьюлдинг орших 9019019096 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Саусгоби Сэндс" ХХК-ийн Байгаль орчны асуудал хариуцсан орлогч дарга Догмидсанги овогтой Ариунболд нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2017-01-01-ний өдрөөс 2017 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт

- Ахуйн
- Уурхайгаас шавхан зайлцуулах

2.2. Ашиглах усны хэмжээ

2.2.1. Унд ахуйн хэрэгцээнд 22612м³/жил

2.2.2. Үйлдвэрлэлд 174182.4 м³/жил

2.2.3. Биологийн нөхөн сэргээлтэд 432 м³

2.2.4. Нийт ашиглах усны хэмжээ 197226.4м³/жил

2.3. Усны чанар, найрлага

Найрлага	1.WS-CS HCO ₃ -2.37; Cl-86.15; SO ₄ -11.48, Na+K-77.10 2.WS-WGHCO ₃ -28.3; Cl-29.19; SO ₄ -42.22, Na+K-56.88 3.WS-GS HCO ₃ -3.4; Cl-49.7; SO ₄ -11.66, Na+K-
----------	--

	50.10 4.WS-E1HCO ₃ -4.2; Cl-88.7; SO ₄ -29.49, Na+K-42.10
Чанар	4-н худгийн усны дээжид шинжилгээ хийж үзэхэд хлорын ангийн, натрийн бүлгийн, 3-р төрлийн, давсархаг, маш хатуу, тэмэртэй ус мөн сульфатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, цэнгэгдүү, зөөлөвтөр ус тус тус зонхицж байна.

2.4. Усны эх үүсвэрийн:

Орон нутгийн зөвшөөрлийн дагуу хайгуулын төслийн үед гаргасан худаг болон гүний цооногоос хангана.

Байршил	1.Уурхайн ангийн баруун цооног:WS-CS 2.Засварын цехийн урд цооног:WS-WG 3.ШТС-ийн хойд цооног:WS-GS 4.Нар мандах уурхайн зүүн талд: WS-E1
Солбилцол	1. WS-CS:N 43 01 08.6 E 101 17 39.4 ELV - 1553 2. WS-WG: N 42 59 14.2 E 101 12 22.2ELV - 1507 3. WS-GS: N 42 59 23.5 E 101 19 49.8ELV - 1527 4. WS-E1: . N 43 00 23.2 E 101 16 36.6ELV - 1531
Барилга байгууламж	3:2.4м харьцаатай энгийн хийцтэй (сэндэвчин)
Тоног төхөөрөмжийн нэр, марк	Хударт Tsurumi EPT2-150DD маркийн 2ш, godwin HL 160m 2ш, godwin CD160m 2ш

2.5. Хаягдал усны Хэмжээ: унд ахуйгаас гарах хаягдал бохир усны хэмжээ

Бохир ус

Хаягдал ус

Нийт хаягдал ус

Стандартын шаардлага: MNS4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны стандартыг ханган ажиллана.

Бохир ус зайлцуулах цэг:

Гурвантэс сумын Засаг Даргын 2014 оны 02-р сарын 27-ний өдрийн А/29 захирамжийн дагуу зөвшөөрөгдсөн цэгт цэвэрлэх байгууламжаас гарсан лагийг хаяна.

Солбилцол	N 42° 59' 48.42055 E 101° 17' 29. 35759
Талбай	20 м ²
Эзэлхүүн	40 м ³

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимиийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг.....

Органик бодис, кг.....

Эрдэс бодис, кг

Хүнд металл, кг.....

Аюултай бохирдуулах бодис, кг.....

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин.

Бээжин хотын “Бээжин Лонгэхуачин Архитектор Дизайн ХХК”-ний суурилуулсан төхөөрөмж. Бохир усыг 1.Физик, 2.Химийн шүүлтүүр гэсэн дарааллаар ариутгаж 90% хүртэл цэвэрлэдэг

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдол, бохирдооос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

Гадаргын болон гүний ус	Серөг нөлөөлөл	Серөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	төсөв	Хариуцах эзэн	Аргачлал, стандарт
Тоос тоосонцор нь тунадасжин бууж, гадаргын болон гүний ус бохирдуулах	Олон салаа зам гаргахгүй зөвхөн зөвшөөрөгдсөн. замаар, хурдны хязгаартай машин техник зорчих	Хурдны хязгаарын замын тэмдэг байрлуулах	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭАБО, Уулын ашиглалт	Овоот Толгой уурхайн замын хөдөлгөөн ий журам	
Усны хэрэглээ ихсэх болон ус шавхалтын үйл ажиллагааны улмаас төслийн талбай, түүний орчмын газрын доорх усны түвшин буурах	Уурхай болон уурхай орчмын усан хангамж, ус ашиглалтыг тогтмол хянах, цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахин ашиглах	Усны хэрэглээг тогтмол хянах, цэвэршүүлсэн бохир усыг жорлон, ногоон байгууламж, замын усалгаанд эргүүлэн ашиглах	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭАБО, Захиргаа	Ус ашиглалт хяналт	
Усны өнөөгийн боломжит эх үүсвэрүүд хомсдох	Уурхайн ус ашиглалт түүний нөөцийг холбогдох газраас баталгаажуулах	Жил бүр ус ашиглалтын дүгнэлт гарч, гэрээ байгуулан ажиллана	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭАБО хэлтэс Холбогдох байгууллага	Усны тухай хууль	
Химийн бодис материал шатах тослох	Химийн бодис болон шатах, тослох	Химийн бодис материалын агуулах, ШТС-н	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭАБО, Засвар, Ашиглалтын	Ажлын байрны үзлэг	

	материалын алдалт, асгаралтаас усны чанарт нөлөөлөх, бохирдох	материалыг хадгалалт ашиглалтанд тогтмол хяналт тавих	агуулахад тогтмол үзлэг хийгдэх	а	хэлтэс Агуулах	болон дотоод хяналт шалгалт
	Ахуйн бохир ус алдагдах	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн горимонд ажлуулах	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд өдөр бүр машинист хяналт тавьж ажиллана	Дотоод үйл ажиллагаа	ХАБЭАБО, Захиргааны хэлтэс	Бохир ус цэвэрлэх байгууламжийн ерөнхий шаардлага, Цэвэршүү лсэн бохир усны стандарт MNS 4943:2011, MNS 11885:2007

2.9. Усны тоолуурын:

Ахуйн хэрэглээнд ашигладаг худагуудад баталгаажуулсан тоолуур суурилуулсан

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

“Усны экологи эдийн засгийн үнэлгээг батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 тоот тогтооолоор Алтайн Өвөр говийн сав газарт тогтоосон усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326,327-р тогтооолор ашиглалтын зориулалтын итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож, тогтоосон хэмжээгээр Төсвийн тухай хуулийн 23.8.9-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

1 м3 усны нөөц ашигласны төлбөр – 4433 төг x 15% x 1,2 = 797.94 төг

Шавхан зайлцуулах усны төлбөрийн хэмжээ 174182.4 м3/жил x 797.94 төг = 138987104,2 төг

2.10.1 Усны эх үүсвэр дээр суурилуулсан, баталгаажуулсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг төлж барагдуулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.7 Ус бохирдуулсны төлбөрийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1, 7.2 үндэслэн /Засгийн газрын тогтоол гарснаар хүчин төгөлдөр болно/ барагдуулна.


4.8 Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 заасны дагуу тоолуур суурилуулаагүй тохиолдолд дүгнэлтэд заасан хэмжээний дагуу ус ашигласаны төлбөрийг барагдуулах.

4.9 Уурхайн ухалгаас усыг шавхан зайлуулахдаа баталгаат тоолуур суурилуулан усны төлбөрийг бодит хэмжээнд тулгуурлан төлж ажиллах, тоолуур суурилуулаагүй тохиолдолд гэрээ болон дүгнэлтэд заасны дагуу төлбөрийг төлж барагдуулах.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ ГАЗР
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
УСНЫ НӨӨЦ, АШИГЛАЛТЫН
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН.

 /Б.АЛТАНТУЛГА/

Ус ашиглагчийг төлөөлж:

САУСГОБИ СЭНДС ХХК-НИЙ
БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОРЧ ДАРГА.
 /Д.АРИУНБОЛД/

Хаяг: Өмнөговь аймаг,
Даланзадгад сум, 3 баг
Төрийн банк байр
Харилцах утас: 70534080
Факс: 70534081

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрг,
15-р хороо, Оргил стадион 22,
Моннис Бьюлдинг
Харилцах утас: 70070710
Факс: 70070720